



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/9/СТА-ТШЗ

| | |
|-----------------------|---|
| Баянхонгор 2021 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Цэрэнчимэд Утас: 99890393 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn |
|-----------------------|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

| | |
|--|----|
| 1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/..... | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 9 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 9 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 11 |
| 3.Аудитын тайлан | 12 |
| 3.1. Ерөнхий зүйл | 12 |
| 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй | 12 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт..... | 13 |
| 3.4. Материаллаг байдал | 13 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 13 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт..... | 15 |
| 3.7. Шилэн дансны мэдээлэл | 16 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 16 |
| 3.9. Аудитын илрүүлэлт | 16 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил | 16 |
| Аудитын зөвлөмж | 16 |
| 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд..... | 16 |
| 4. Менежментийн захидал..... | 16 |
| 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт..... | 18 |



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Э.НАНДИНБИЛЭГ ТАНАА

2021.02.25 № 2/143

танай _____ -ны № _____ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажилласан байна.

Тус байгууллага нь ковид-19 цар тахал онцгой дэглэмийн үед аймаг, сумын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

2021 А4 ТООТ

005020121

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>77,983,713.60</u> | <u>131,354,275.60</u> |
| 33 | АВЛАГА | 00.00 | 9,897,600.00 |
| 335 | Бусад авлага | 00.00 | 9,897,600.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 00.00 | 9,897,600.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 77,983,713.60 | 95,337,113.60 |
| 351 | Түүхий эд материал | 3,370,150.00 | 3,370,150.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,370,150.00 | 3,370,150.00 |
| 354 | Хангамжийн материал | 74,613,563.60 | 91,966,963.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,449,000.00 | 1,999,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,337,600.00 | 17,141,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 247,500.00 | 1,800,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 217,300.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 57,362,163.60 | 71,026,863.60 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 00.00 | 26,119,562.00 |
| 36600 | Бусад нөөц | 00.00 | 26,119,562.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>646,138,008.71</u> | <u>657,118,912.62</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 646,138,008.71 | 657,118,912.62 |
| 392 | Биет хөрөнгө | 619,362,008.71 | 630,342,912.62 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 583,196,600.00 | 590,196,600.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -36,407,901.46 | -49,407,425.98 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 116,339,640.60 | 133,957,792.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -85,022,773.99 | -96,595,981.27 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 61,827,853.18 | 75,198,053.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -34,118,673.63 | -39,521,289.96 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,009,000.00 | 6,009,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,055,891.19 | -3,891,791.15 |
| 39217 | Ном | 10,594,155.20 | 14,397,955.20 |
| 393 | Биет бус хөрөнгө | 26,776,000.00 | 26,776,000.00 |
| 39301 | Програм хангамж | 875,000.00 | 675,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -875,000.00 | -675,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26,776,000.00 | 26,776,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>724,121,722.31</u> | <u>788,473,188.22</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>724,121,722.31</u> | <u>788,473,188.22</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 724,121,722.31 | 788,473,188.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 417,388,192.00 | 417,388,192.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 417,388,192.00 | 417,388,192.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -147,043,944.69 | -82,692,478.78 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -147,043,944.69 | -147,043,944.69 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 64,351,465.91 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 453,777,475.00 | 453,777,475.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>724,121,722.31</u> | <u>788,473,188.22</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 661,467,000.00 | 780,510,876.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 11,449,000.00 | 13,077,652.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 11,449,000.00 | 13,077,652.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,449,000.00 | 13,077,652.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 11,449,000.00 | 13,077,652.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 82,304,600.00 | 113,477,524.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 567,713,400.00 | 653,955,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 55,929,600.00 | 64,771,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,929,600.00 | 64,771,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 621,458,356.80 | 716,159,410.09 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 620,559,356.80 | 716,159,410.09 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 600,438,256.80 | 626,449,728.55 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 383,821,768.00 | 428,344,331.03 |
| 210101 | Үндсэн цалин | 277,284,094.00 | 298,919,944.99 |
| 210102 | Нэмэгдэл | 19,733,768.00 | 60,436,281.14 |
| 210104 | Урамшуулал | 65,905,906.00 | 50,077,584.37 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,898,000.00 | 18,910,520.53 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,977,033.00 | 60,294,473.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,036,633.00 | 36,239,520.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,485,300.00 | 10,432,264.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,788,200.00 | 3,862,670.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 697,000.00 | 1,091,417.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,969,900.00 | 8,668,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 49,407,100.00 | 58,769,928.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,631,968.00 | 2,877,962.00 |
| 210302 | Түлш, халаалт | 43,975,132.00 | 54,091,966.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,290,920.00 | 10,172,810.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,424,800.00 | 1,854,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,368,000.00 | 4,203,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,357,400.00 | 229,510.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 357,200.00 | 361,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 536,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,603,520.00 | 2,987,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 44,064,480.00 | 25,159,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 477,480.00 | 699,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 42,477,200.00 | 21,255,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,109,800.00 | 3,203,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 26,500,000.00 | 1,575,338.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,500,000.00 | 1,575,338.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,650,400.00 | 1,282,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,650,400.00 | 1,282,000.00 |

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,080,000.00 | 4,854,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,680,000.00 | 4,404,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 450,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,646,555.80 | 35,997,348.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,977,400.00 | 3,646,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,325,600.00 | 1,539,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,343,555.80 | 30,811,248.09 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20,121,100.00 | 89,709,681.54 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 18,180,400.00 | 58,750,374.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,969,000.00 | 8,828,850.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 5,439,624.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 43,041,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,211,400.00 | 1,440,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,940,700.00 | 1,449,072.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,940,700.00 | 1,449,072.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 29,510,235.54 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 29,510,235.54 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 899,000.00 | 00.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 899,000.00 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 899,000.00 | 00.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 40,008,643.20 | 64,351,465.91 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 7,699,059.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 7,699,059.00 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -7,699,059.00 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 32,309,584.20 | 64,351,465.91 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 650,018,000.00 | 767,433,224.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 650,018,000.00 | 767,433,224.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 567,713,400.00 | 653,955,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 567,713,400.00 | 653,955,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 55,929,600.00 | 64,771,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,929,600.00 | 64,771,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 650,018,000.00 | 738,508,724.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 650,018,000.00 | 738,508,724.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 629,435,900.00 | 647,874,042.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 388,434,100.00 | 428,362,594.03 |

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| 210101 | Үндсэн цалин | 288,430,555.00 | 298,919,942.99 |
| 210102 | Нэмэгдэл | 22,737,704.00 | 60,454,544.14 |
| 210104 | Урамшуулал | 56,167,841.00 | 50,077,586.37 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,098,000.00 | 18,910,520.53 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49,379,100.00 | 60,288,810.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,438,700.00 | 36,387,827.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,485,300.00 | 10,574,694.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,788,200.00 | 3,420,670.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 697,000.00 | 869,217.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,969,900.00 | 9,036,400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 49,429,600.00 | 60,322,428.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,415,500.00 | 2,877,962.00 |
| 210302 | Түлш, халаалт | 44,214,100.00 | 55,644,466.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,131,400.00 | 10,472,810.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,381,800.00 | 1,854,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,368,000.00 | 4,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,810,600.00 | 229,510.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,044,400.00 | 361,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 440,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,346,600.00 | 3,287,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 43,179,900.00 | 31,631,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 477,300.00 | 1,349,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,592,700.00 | 20,113,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,109,900.00 | 10,168,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 40,250,000.00 | 31,858,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 4,163,900.00 |
| 210602 | Тавилга | 13,750,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,500,000.00 | 27,694,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,650,400.00 | 1,282,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,650,400.00 | 1,282,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 27,096,000.00 | 4,656,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,696,000.00 | 4,206,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 450,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,885,400.00 | 18,998,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,999,800.00 | 7,024,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,885,600.00 | 11,974,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20,582,100.00 | 90,634,681.54 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 18,641,400.00 | 59,675,374.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,430,000.00 | 9,753,850.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 5,439,624.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 43,041,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,211,400.00 | 1,440,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,940,700.00 | 1,449,072.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,940,700.00 | 1,449,072.00 |

| | | | |
|--------|---|--------------|-----------------------|
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 29,510,235.54 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 29,510,235.54 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 28,924,500.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 00.00 | 28,924,500.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 28,924,500.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 28,924,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 28,924,500.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 00.00 | -28,924,500.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 417,388,192.00 | 453,777,475.00 | -147,043,944.69 | 724,121,722.31 |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 417,388,192.00 | 453,777,475.00 | -147,043,944.69 | 724,121,722.31 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 417,388,192.00 | 453,777,475.00 | -147,043,944.69 | 724,121,722.31 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 64,351,465.91 | 64,351,465.91 |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 417,388,192.00 | 453,777,475.00 | -82,692,478.78 | 788,473,188.22 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|-----------------------------------|-----------------------|----------------|---------------|-------|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 718,727,200.00 | 687,767,892.46 | 30,959,307.54 | 95.7 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 718,727,200.00 | 687,767,892.46 | 30,959,307.54 | 95.7 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 697,014,300.00 | 676,574,042.46 | 20,440,257.54 | 97.1 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 440,410,600.00 | 428,362,594.03 | 12,048,005.97 | 97.3 |
| Үндсэн цалин | 305,579,600.00 | 298,919,942.99 | 6,659,657.01 | 97.8 |
| Нэмэгдэл | 59,531,900.00 | 60,454,544.14 | -922,644.14 | 101.5 |
| Урамшуулал | 52,729,300.00 | 50,077,586.37 | 2,651,713.63 | 95.0 |
| Гэрээт ажлын хөлс | 22,569,800.00 | 18,910,520.53 | 3,659,279.47 | 83.8 |

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | |
|--|---------------|---------------|---------------|-------|
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 62,118,900.00 | 60,288,810.43 | 1,830,089.57 | 97.1 |
| Тэтгэврийн даатгал | 44,098,400.00 | 36,387,827.83 | 7,710,572.17 | 82.5 |
| Тэтгэмжийн даатгал | 4,505,100.00 | 10,574,694.30 | -6,069,594.30 | 234.7 |
| ҮОМШӨ-ний даатгал | 3,604,100.00 | 3,420,670.63 | 183,429.37 | 94.9 |
| Ажилгүйдлийн даатгал | 901,100.00 | 869,217.67 | 31,882.33 | 96.5 |
| Эрүүл мэндийн даатгал | 9,010,200.00 | 9,036,400.00 | -26,200.00 | 100.3 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 61,771,500.00 | 60,322,428.00 | 1,449,072.00 | 97.7 |
| Гэрэл, цахилгаан | 4,315,500.00 | 2,877,962.00 | 1,437,538.00 | 66.7 |
| Түлш, халаалт | 55,656,000.00 | 55,644,466.00 | 11,534.00 | 100.0 |
| Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,800,000.00 | 00.00 | 100.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 13,338,800.00 | 13,335,510.00 | 3,290.00 | 100.0 |
| Бичиг хэрэг | 1,854,400.00 | 1,854,400.00 | 00.00 | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 4,300,000.00 | 4,300,000.00 | 00.00 | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 232,800.00 | 229,510.00 | 3,290.00 | 98.6 |
| Ном, хэвлэл | 3,224,000.00 | 3,224,000.00 | 00.00 | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 440,000.00 | 440,000.00 | 00.00 | 100.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,287,600.00 | 3,287,600.00 | 00.00 | 100.0 |
| Нормативт зардал | 35,839,000.00 | 31,631,600.00 | 4,207,400.00 | 88.3 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,349,900.00 | 1,349,900.00 | 00.00 | 100.0 |
| Хоол, хүнс | 24,321,000.00 | 20,113,600.00 | 4,207,400.00 | 82.7 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,168,100.00 | 10,168,100.00 | 00.00 | 100.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 49,944,900.00 | 49,944,900.00 | 00.00 | 100.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 15,250,000.00 | 15,250,000.00 | 00.00 | 100.0 |
| Урсгал засвар | 34,694,900.00 | 34,694,900.00 | 00.00 | 100.0 |
| Томилолт, зочны зардал | 2,184,400.00 | 1,282,000.00 | 902,400.00 | 58.7 |
| Дотоод албан томилолт | 2,184,400.00 | 1,282,000.00 | 902,400.00 | 58.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,432,000.00 | 4,432,000.00 | 00.00 | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,982,000.00 | 3,982,000.00 | 00.00 | 100.0 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 450,000.00 | 00.00 | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 26974200.00 | 26974200.00 | 00.00 | 100.0 |

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | |
|--|----------------|----------------|---------------|-------|
| Барaa үйлчилгээний бусад зардал | 15,000,000.00 | 15,000,000.00 | 00.00 | 100.0 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,974,200.00 | 11,974,200.00 | 00.00 | 100.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 21712900.00 | 11193850.00 | 10,519,050.00 | 51.6 |
| Бусад урсгал шилжүүлэг | 21,712,900.00 | 11,193,850.00 | 10,519,050.00 | 51.6 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,768,000.00 | 9,753,850.00 | 4,014,150.00 | 70.8 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,944,900.00 | 1,440,000.00 | 6,504,900.00 | 18.1 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 718,727,200.00 | 687,767,892.46 | 30,959,307.54 | 95.7 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 653,955,700.00 | 624,445,464.46 | 29,510,235.54 | 95.5 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 653,955,700.00 | 624,445,464.46 | 29,510,235.54 | 95.5 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 64,771,500.00 | 63,322,428.00 | 1,449,072.00 | 97.8 |
| Орон нутгийн төсвөөс | 64,771,500.00 | 63,322,428.00 | 1,449,072.00 | 97.8 |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | 38 | 38 | - | 100.0 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 26 | 26 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 5 | 5 | - | 100.0 |
| Гэрээт ажилтан | 6 | 6 | - | 100.0 |
| СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 291 | 281 | 10 | 96.6 |
| ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 291 | 281 | 10 | 96.6 |
| Төрийн өмчит ЕБС | 291 | 281 | 10 | 96.6 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|---|---------------|---------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| 2109 | Барaa үйлчилгээний бусад зардал | 26,375,000.00 | 224,500.00 |
| 210901 | Барaa үйлчилгээний бусад зардал | 26,375,000.00 | 224,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 48,481,524.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 48,481,524.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 5,439,624.00 |

| | | | |
|-------------|--|---------------|---------------|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 43,041,900.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,375,000.00 | 48,706,024.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Э.Нандинбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 11-ээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 11 дугаар сарын 11-ний өдрийн 57 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш бүр ажлын байрандаа тасралтгүй хөгжиж хэрэгцээт хөтөлбөр боловсруулан суралцагчдын сурлагын амжилт чанар, сурах арга барилд ахиц гарган, сурах хөгжих таатай орчин бүрдүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 409623.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8192.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 716159.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 14323.2 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 788473.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 64351.5 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөг/ |
|---|----------------|-----------------|-----------------|
| | | | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 77,983.7 | 131,354.3 | 53,370.6 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 9,897.6 | 9,897.6 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 77,983.7 | 121,456.7 | 43,473.0 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 646,138.0 | 657,118.9 | 10,980.9 |
| Үндсэн хөрөнгө | 805,618.2 | 847,210.4 | 41,592.2 |
| Хуримтлагдсан элэгдэл | (159,480.2) | (190,091.5) | (30,611.2) |
| Нийт хөрөнгө | 724,121.7 | 788,473.2 | 64,351.5 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 724,121.7 | 788,473.2 | 64,351.5 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 724,121.7 | 788,473.2 | 64,351.5 |

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх онд авлагагүй байсан бөгөөд тайлант онд 9897.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Дэвших болор ХХК-руу ухаалаг самбарын үнэ 9885.0 мянган төгрөг шилжүүлээд хөрөнгийг аваагүй, мөн НДХ-ээс авах 12.6 мянган төгрөгийн авлагыг бүртгэжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 121456.7 мянган төгрөг болж 43473.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бичиг хэрэг 550.0 мянга, аж ахуйн материал 1803.5 мянга, түлш шатах тослох материал 1552.5 мянга, бусад хангамжийн материал 13664.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж хүнсний материал 217.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 847210.4 мянган төгрөг болж 41592.2 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламж 7000.0 мянга, машин тоног төхөөрөмж 17618.1 мянга, тавилга эд хогшил 13370.2 мянга, номын фонд 3803.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 200.0 мянган төгрөгийн программ акталж, данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 2020 онд төсвийн хөрөнгөөр барилга байгууламжид 7000.0 мянган төгрөгийн сургуулийн хашаа, 22 нэр төрлийн 17618.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 60 нэрийн 13370.2 мянган төгрөгийн тавилга, 3803.8 мянган төгрөгийн ном худалдан авсан, үндсэн хөрөнгө нийт дүнгээрээ 28421.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн, аймгийн ИТХТ-ийн хурлын 2020.07.06-ны 12 дугаар тогтоолоор 200.0 мянган төгрөгийн программыг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 788473.2 мянган төгрөг болж 64351.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 64351.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 780510.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 119043.8 мянган төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн байна.

Үүнд орон нутгийн санхүүжилтийн орлого 8841.9 мянга, зориулалтын шилжүүлэг 86242.3 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 22331.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Нийт зардал 716159.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 94701.0 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал 50840.0 мянга, байр

ашиглалтын тогтмол зардал 9362.8 мянга, хангамжийн зардал 1881.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 2724.5 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардал 40569.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, нормативын зардал 18905.5 мянга, эд хогшил урсгал засварын зардал 24924.7 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 732570.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 732570.1 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

Тайлант онд дээрх төсөвт 3 удаа зохицуулалт хийж, 13842.9 мянган төгрөгөөр бууруулж, 718727.2 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 732570.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж 3 удаа тодотгол хийн 718727.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 653955.7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 64771.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 64771.5 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 653955.7 мянга, нийт 718727.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 687767.9 мянган төгрөгийг зарцуулж 30959.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 687767.9 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 13878.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 1449.1 мянга, хангамж бараа материалын зардлыг 3.3 мянга, нормативд зардлыг 4207.4 мянга, албан томилолтын зардлыг 902.4 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 10519.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71802 хөтөлбөрийн 80103 арга хэмжээ 3782.1 мянга, 80109 арга хэмжээ 1449.1 мянга, 80802 арга хэмжээ 16504.9 мянга, 81801 арга хэмжээ 4014.2 мянга, 81806 арга хэмжээ 6180.2 мянга, 8134 арга хэмжээ 4313.5 мянга, 81835 арга хэмжээ 2043.5 мянга, 71806 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 2671.9 мянган төгрөгөөр тус тус дутуу хэмнэсэнтэй холбоотой байна.

| № | Нэр | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|--------------|---------------------------------------|------------------|-------------------|-------------------|-------------|
| | НИЙТ ДҮН | 718,727.2 | 687,767.9 | (30,959.3) | 95.7 |
| 71802 | Ерөнхий боловсрол | 709,957.9 | 681,670.4 | (28,287.5) | 96.0 |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, ү | 25,616.7 | 21,834.6 | (3,782.1) | 85.2 |
| 80109 | ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 64,771.5 | 63,322.4 | (1,449.1) | 97.8 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 7,944.9 | 1,440.0 | (6,504.9) | 18.1 |
| 81801 | үдийн цай хөтөлбөр | 13,768.0 | 9,753.9 | (4,014.2) | 70.8 |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 88,295.2 | 82,115.0 | (6,180.2) | 93.0 |
| 81834 | Боловсролын стандарт, сургалты | 392,105.1 | 387,791.6 | (4,313.5) | 98.9 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 117,456.5 | 115,413.0 | (2,043.5) | 98.3 |
| 71806 | Насан туршын болон албан бус б | 8,769.3 | 6,097.4 | (2,671.9) | 69.5 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 8,769.3 | 6,097.4 | (2,671.9) | 69.5 |

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 48706.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 5 жилийн тэтгэмжид 43041.9 мянга, тэтгэвэрт гарахад 5439.6 мянга, сурах бичиг худалдан авахад 224.5 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 139 мэдээллийг хугацаанд нь 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээлэл хугацаа болоогүй байна. Шилэн дансны Төсөв, гүйцэтгэл талбарт 5.0 сая-аас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 914687.3 мянган төгрөгийн 120 гүйлгээ байршуулахаас 797777.4 мянган төгрөгийн 89 гүйлгээ байршуулсан, 116909.8 мянган төгрөгийн 31 гүйлгээг байршуулаагүй байна. Тендер худалдан авалт талбарт 5,0 сая-аас дээш үнийн дүн бүхий 224289.7 мянган төгрөгийн мэдээлэл байршуулахаас 220861.4 мянган төгрөгийн мэдээлэл байршуулж, 3428.2 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2947,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг ажилтны цалингаас суутган шилжүүлж, барагдуулсан байна. Албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайланд алдаа, зөрчил илрээгүй, шилэн дансны сайтад мэдээлэл дутуу, зарим мэдээллийг байршуулаагүй байх тул зөвлөмж өгөв. /Хавсралт 1./

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар санхүүгийн тайланд алдаа, зөрчил илрээгүй, шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой 1 зөвлөмж өглөө.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: НББ-ийн бодлогын баримт бичиг байгаа боловч байгууллагын даргын тушаалаар баталгаажуулаагүй байгаа НББ-ийн тухай хуулийн 18.2. “Аж ахуйн нэгж,

байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн.

1.2.Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн бодлого алдагдах.

1.3.Өгсөн зөвлөмж: НББ-ийн бодлогын баримт бичгийг байгууллагын даргын тушаалаар баталгаажуулах

1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2.1.Илрүүлэлт: Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 139 мэдээллийг хугацаанд нь 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээлэл хугацаа болоогүй байна. Шилэн дансны Төсөв, гүйцэтгэл талбарт 5.0 сая-аас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 914687.3 мянган төгрөгийн 120 гүйлгээ байршуулахаас 797777.4 мянган төгрөгийн 89 гүйлгээ байршуулсан, 116909.8 мянган төгрөгийн 31 гүйлгээг байршуулаагүй байна. Тендер худалдан авалт талбарт 5,0 сая-аас дээш үнийн дүн бүхий 224289.7 мянган төгрөгийн мэдээлэл байршуулахаас 220861.4 мянган төгрөгийн мэдээлэл байршуулж, 3428.2 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

2.2.Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

2.3.Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэр, батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ, тендерийн ерөнхий мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

2.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Б.ЦЭРЭНЧИМЭД 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.25



5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|-------------------------------------|---|--|---------------------|
| Огноо | Аудитын нэр: | Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
| 2020 | | | БНА-2021/9/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|------------|---------------------------------------|---|--------------------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 139 мэдээллийг хугацаанд нь 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан | 0 | зөвлөмж | Захирал, нягтлан бодогч | Э.Нандинбилэг, С.Ганболд |
| 2 | НББ-ийн бодлогын баримт бичиг байгаа боловч байгууллагын даргын тушаалаар баталгаажуулаагүй байна. | 0 | зөвлөмж | Захирал, нягтлан бодогч | Э.Нандинбилэг, С.Ганболд |
| | ДҮН | 0 | | | |

оОо